



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

№11 /225/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.01.13

Цаг үе, үйл явдал

Ж.Болдбаатар: ЭРСДЭЛТЭЙ ЦАГ ҮЕД БИДНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАМГИЙН ЧУХАЛ



Зэвсэгт хүчний Жанжин штабын Удирдлагын шуурхай бүлэг болон салбарын хэмжээнд "Ковид-19"-ын шинэ омог "Омикрон"-ны халдвараас урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай танилцах хуралд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар оролцон санал хүсэлтээ илэрхийлж, тодорхой үүрэг чиглэлийг өгч ажиллалаа. Тус хурлаар ЗХЖШ-ын Ажиллагааны удирдалгын газрын Ажиллагааны удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн дэд хурандаа П.Мөнх-Эрдэнэ Удирдлагын шуурхай бүлгийн талаар, Эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн дэд хурандаа Э.Бямбадорж Зэвсэгт хүчний хэмжээнд, Цэргийн төв эмнэлгийн дарга, ерөнхий эмч хурандаа Б.Энх-Од Цэтгийн төв эмнэлгийн, Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын

дарга хурандаа Г.Ялалт нийслэлийн хэмжээнд дэх цэргийн штабуудын "Ковид-19", "Омикрон"-ны халдварын эсрэг авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар танилцууллаа. Энэ үеэр бригадын генерал Ж.Болдбаатар "Та бүхэнд дараах үүрэг чиглэлийг өгч байна. Нэгдүгээрт, шинэ он гарахтай зэрэгцээд "Омикрон"-ны халдвар ихэссэнтэй холбоотойгоор түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж уриалга гаргах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр анхааруулга, санал хүргэх ажлыг зохион байгуулах. Хоёрдугаарт, Улсын Онцгой комиссын Шуурхай штабтай мэдээллээ түргэн хугацаанд шуурхай солилцож хамтран ажиллах. Гуравдугаарт, мэдээлэл, судалгааны ажлаа улам чамбайруулах шаардлага байна. Дөрөвдүгээрт, эмнэлгийн нэг удаагийн

хамгаалах хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх тал дээр анхаарах. Тавдугаарт, хугацаат цэргийн алба хаагчдын халдвар хамгааллыг сахиулж, урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын тал дээр тодорхой ажлуудын зохион байгуулах. Зургаадугаарт, дархлаажуулалтын дөрөвдүгээр тунгийн ажлыг эрчимжүүлэх, долоодугаарт, сар шинийн баяраар золголт хийх нэрийдлээр хөдөө орон нутаг руу явах хөдөлгөөн ихэсдэг. Үүнтэй холбогдуулан алба хаагчийн хөдөө орон нутаг руу зорчих хөдөлгөөнийг аль болох хязгаарлахыг уриалж, зөвхөн гэр бүлийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх талаар анхааруулга, шторк, баннерыг байршуулах шаардлагатай. Наймдугаарт, Цэргийн төв эмнэлгийн хувьд шаардлагатай байгаа зүйлсээ БХЯ-нд албан бичгээр ирүүлээрэй гэсэн үүргийг өгч байна" гэв.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНУУДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ

Зэвсэгт хүчний бодлого зорилт, үйл ажиллагааг хэвлэл мэдээлэлээр сурталчлах ажилд мэргэжлийн холбоод болон хэвлэл мэдээллийн оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэх, тэдгээр байгууллагуудын удирдах албан тушаалтнуудад Зэвсэгт хүчний бодлого зорилт, үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, ЗХЖШ болон хэвлэл мэдээллийн албаны 2021 оны үйл ажиллагааны товч тайланг танилцуулах, цаашдын хамтын ажиллагааны зорилго, чиглэлийг тодорхойлох, нэгдсэн ойлголтод хүрэх зорилгоор ЗХЖШ-ын удирдлагууд өнөөдөр хэвлэл мэдээллийн байгууллагуудын удирдах алба тушаалтнуудыг хүлээн авч уулзалт хийлээ.

Уулзалтад ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, орлогч дарга бригадын генерал Ч.Цогтжаргал, I орлогч дарга бригадын генерал С.Ганбямба, ЗХЖШ-ын ахлагч тэргүүн ахлагч Д.Баасан, ЗХЖШ-ын БСТГ-ын дарга бригадын генерал Ц.Гандорж, АУГ-ын дарга бригадын генерал С.Дашзэвэг, ЗУХ-ийн дарга хурандаа Д.Номт болон төрлийн цэргийн зарим командлалын удирдлагууд оролцов. Эл уулзалтын арга хэмжээг нээж ЗХЖШ-ын I орлогч дарга бригадын генерал С.Ганбямба хэлсэн үгэндээ, "Цэрэг эх оронч, үндэсний бахархалт үзэл хүмүүжилтэй иргэнийг төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагуудын үүрэг оролцоо чухал бөгөөд эл үүргийг гүйцэтгэж, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг өөрсдийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан олон нийтэд сурталчлан таниулж, бидний ажлыг дэмжин хамтран ажиллаж буй та бүхэнд талархал илэрхийлье" хэмээн

онцолж байлаа. Мөн тэрээр ЗХЖШ-аас 2021 онд хэрэгжүүлсэн томоохон ажлууд, онцлог арга хэмжээнүүдийн талаар товч мэдээлэл өгсөн юм. Тэрчлэн ЗХЖШ-ын Хэвлэл мэдээллийн албаны дарга хурандаа Б.Отгонбаяр өнгөрөгч онд хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиглэлээр хэрхэн ажилласан, ямар ажлуудыг өрнүүлж, түүнийгээ аль сонин, сайт, ТВ-үүдээр олон нийтийн хүртээл болгон сурталчилсан талаараа товч тайлагнав. Харин хэвлэл мэдээллийн байгууллагуудын удирдлагуудыг төлөөлж Монголын сэтгүүлчдийн нэгдсэн гүйцэтгэх ерөнхийлөгчийг түр орлон гүйцэтгэгч З.Борбилмаа хэлсэн үгэндээ, "Харилцан бие биеийнхээ ажлыг ойлгож, хамтран ажиллахад аль ч хэвлэл мэдээллийн байгууллагын үүд хаалга нээлттэй байх болно. Харин та бүхэн үнэн бодит мэдээ мэдээлэлээр хангаж ажиллах учиртай" хэмээн тодотгоод "Энэ удаагийн уулзалт үр дүнтэй болно гэдэгт итгэл төгс байна" гэв. Үүний дараа орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан 2021 онд Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр идэвх санаачилгатай ажилласан МСНЭ-ийн ерөнхийлөгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Борбилмаа, гүйцэтгэх захирал Э.Болортулга, хуулийн зөвлөл Г.Балжмаа, МҮОНТ-ийн ерөнхий продюсер Д.Ганчимэг, редактор Ц.Одонтуяа, "Монголын мэдээ" агентлагийн ерөнхий продюсер Ц.Цэнд нарын 20 хүнийг ЗХЖШ-ын даргын тушаалаар ЗХЖШ-ын Хүндэт жуух бичгээр шагнасан юм. Шагнагч гардуулж, дурсгалын зураг авчуулсны дараа ЦДБЭЧ-ын уран бүтээлчид хэсэгчилсэн тоглолтоо толилуулав.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2.267.296 /69.7%/	2.166.817 /66.6%/	946.536 29,1%

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
7454 +112	185	7153

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол	Нийт: 314,090,366
Эдгэрсэн	Нийт: 261,659,479
Нас барсан	Нийт: 5,521,031

Түүхэнд энэ өдөр

1912 он.

Улиастай хотыг чөлөөлж, Манжийн амбанг хөөв.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-10	-27

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	22

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,852.00	2,854.0
EUR	3,260.0	3,270.0
CNY	448.30	449.00
RUB	38.80	39.50
JPY	24.65	24.80
KRW	2.39	2.41

ЗУРХАЙ

2022.01.013 ПҮРЭВ ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 11/

ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САРЫН НАЙМАН МЭНГЭТЭЙ ЦАГААН УЛААН БАР ӨДӨР

Үс засуулбал: Эрхтэн хурц болно.
НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 08.38-17.23
Барилдлага: Хүчин төгсөх
Шүтэн барилдлага: Төрөхүй
Суудал: Төмөр

Энэ өдөр морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, сан тавиулах, угаал үйлдэх, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Золиг гаргах, бомбын үйл, сэтгэлд сэвтэй газар очих, хүүхэд хөлд оруулахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрхтэн хурц болно.

ОЛОН УЛСЫН ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛСЭН САЛБАРЫН ХОЁР ДАХЬ БАЙГУУЛЛАГА БОЛЛОО



ирсэн бөгөөд стандарт нь тогтвортой хөгжилд хүрэх, нийгэм, эдийн засаг, байгаль орчны талаар зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл-хөгжлийн түлхүүр мөн юм. Тиймээс олон улсын стандартыг нэвтрүүлж байгаа танай байгууллага нь эх орныхоо хөгжил цэцэглэлтэд үнэт хувь нэмэр оруулж байгаа гэж ойлгож болно. Ингээд "Чанар гэр бүл"-д тавтай морил, танай байгууллагын үйл ажиллагаа улам төгөлдөржих болтугай" гэв.

Батлан хамгаалахын аж үйлдвэрийн нэгдлийн дэд захирал бэлтгэл хурандаа Ө.Батмөнх "Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн 30 жилийн ойн өдөр манай үйлдвэрт олон улсын чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлсэн гэрчилгээ болон бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээг Стандарт хэмжил зүйн газраас олголоо. Ингэснээр "Соёмбот" цэвэр усны үйлдвэр нь олон улсын чанарын менежментийн тогтолцоо, бүтээгдэхүүний чанарын стандартыг нэвтрүүлсэн Батлан хамгаалах салбарын хоёр дахь байгууллага боллоо" хэмээн дурдсан юм.

Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газраас "Батлан хамгаалахын аж үйлдвэрийн нэгдэл" ТӨААТҮГ-ын "Соёмбот" цэвэр усны үйлдвэрт "ISO 9001:2015" гэрчилгээг гардуулж өглөө. Тус гэрчилгээг олон улсын чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн байгууллагад өгдөг ажээ.

Стандарт хэмжил зүйн газрын баталгаажуулалтын газрын дарга В.Ганзориг "Цар тахал дэгдсэн энэ хүнд үед олон нийтийн төлөө байгууллагынхаа үйл ажиллагааг улам төгөлдөржүүлж, чанарын стандартыг нэвтрүүлж байгаад та бүхэнд баяр хүргэе. Жил бүрийн 10 дугаар сарын 14-нд "Дэлхийн Стандартын өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэ өдрийг стандартчиллын үйл хэрэгт мэдлэг, оюун, сэтгэл зүрхээ зориулж ирсэн 160 гаруй орны 100 мянга гаруй мэргэжилтнүүд тэмдэглэж байна. Монгол Улсын хувьд 2015 оноос энэ өдрийг "Стандарт-Хэмжил зүйн ажилтны өдөр" болгон тэмдэглэж ирсэн. Улс орны маань нийгэм, эдийн засгийн хөгжилтэй уялдан стандартчиллын үүрэг роль өөрчлөгдсөөр



ЦЭРГИЙН БҮРТГЭЛ ЯВАГДАЖ БАЙНА



яам нэгдсэнтэй холбогдуулж 2022 оны цэргийн бүртгэлийг цахимаар зохион байгуулж байгаа нь онцлог ажил болж байна. Иймд иргэдэд гар утсанд "E-mongolia" аппликейшныг хэрхэн суулгаж, үүнийгээ ашиглан цэргийн бүртгэлд яаж хамрагдах талаар зааварчилгааг өгч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд энэ сарын 12-ны өдрийн байдлаар 798 иргэн "E-mongolia" аппликейшн ашиглан цэргийн бүртгэлд хамрагдсан байна.

Хэнтий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Аймгийн Засаг даргын А/01 дүгээр захирамжийн дагуу 2022 оны цэргийн бүртгэл энэ сарын 10-20-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд явагдаж байна. Батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу Баянхутаг, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Мөрөн, Биндэр, Баян-Адарга, Дадал, Норовлин, Батноров сумдад шалган туслах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Энэ жилийн хувьд төрийн цахим систем "E-mongolia"-д Монгол Улсын Батлан хамгаалах



Цахим шууданд

"БӨРТЭ"-ИЙНХӨН ЗАГВАРЫН ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОВ

"Бөртэ" ТӨААТҮГ-ын Үйлдвэрлэлийн албаны ажилчдын мэргэжлийн ур чадвар, загвар зохион бүтээх чадамжийг нээн илрүүлж, шинэ санаа, байгууллагын брэнд бүтээгдэхүүнийг бий болгох зорилгоор загвар зохион бүтээх уралдааныг зохион шилдгүүдээ тодрууллаа.

Тус уралдаанд Захиалгын тасгийн "Баялаг бүтээгч баг", 1 дүгээр тасгийн "Эрч хүч 1", "Эрч хүч 2", 2 дугаар тасгийн "Ирээдүйн өөдөө", "Хилчин", Эсгүүрийн тасгийн "Цоглог залуус", Үйлдвэрлэлийн албаны "5.1" зэрэг 7 багийн



12 оёдолчин оролцож 25 нэр төрлийн хувцас хэрэглээг өрсөлдөө.

Тэмцээний шүүгчид шалгуур үзүүлэлтийн дагуу шүүж дүнгээ гаргасан бөгөөд материал сонголт, үлгэр болон загвараа гаргасан байдал, давуу тал онцлог, хувцасны таарамж зохицолдлогоо зэргийг харгалзан үзэж шалгаруулжээ.

Тэмцээний 1 дүгээр байрыг "Баялаг бүтээгч", 2 дугаар байрыг Эсгүүрийн тасгийн "Цоглог залуус", тусгай байрыг тусгай захиалгын тасгийн оёдолчин Л.Баярмаа шалгарсан юм.

"ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЗӨВЛӨЛ" НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГАА АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй мотобуудлагын батальоны энхийг сахиулагч эмэгтэй цэргийн алба хаагчдын хуралдаанаар "Эмэгтэйчүүдийн зөвлөл"-ийг 2022 оны эхний өдөр байгуулан энэ сарын 5-ны өдөр Бентью суурин Хубилай баазад үйл ажиллагааныхаа нээлтийн ёслолын ажиллагааг зохион байгууллаа. Нээлтийн ёслолд батальон, ротын удирдлагууд, батальоны эмэгтэй цэргийн алба хаагчид оролцсон юм. Энэхүү ёслолыг нээж Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга, хүний нөөцийн офицер хошууч М.Хишигбаяр үг хэлэхдээ "Бидний ажлыг дэмжиж байгаа батальоны удирдлагууддаа талархал илэрхийлье. Эмэгтэйчүүдийн зөвлөл халдвар, хамгааллын дэглэмийг баримтлан олон ажлыг зохион байгуулахаар



төлөвлөж байна" хэмээн дурдаад тус зөвлөлийн гишүүдийг танилцууллаа.

Үүний дараа мотобуудлагын батальоны захирагчийн орлогч, штабын дарга дэд хурандаа Н.Гантөмөр "Эмэгтэйчүүдийн зөвлөл байгуулагдан үйл

ажиллагаагаа эхэлж байгаа нь олзуурхууштай.

Эмэгтэй цэргийн алба хаагчдын хувьд эрчүүдээс дутахгүй, хариуцсан үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгаад талархал илэрхийлье. Бидэнд цаашид хэрэгжүүлэх олон ажил байгаа бөгөөд тэр бүхэнд идэвхтэй оролцон, хамт оныхоо уур амьсгалыг зөөллөж, илүү санаачилгатай байгаарай" гэлээ. Түүнээс гадна батальоны захирагч хурандаа О.Заяат "Эмэгтэйчүүд" сэдвээр лекц тавьсан юм.

Төгсгөлд нь "Эмэгтэйчүүдийн зөвлөл"-өөс санаачилсан урлагийн болон "Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлцгээе" богино хэмжээний жүжигчилсэн тоглолт, "60 секунд" хөгжөөнт тэмцээн зэргийг зохион байгууллаа.

Ахлах дэслэгч Ц.БАДАМСҮРЭН

